



БАЯНХОНГОР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2024 | II



Агуулга

НЭГ. АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР.....	3
БҮЛЭГ I НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ	5
I Нийгмийн халамж	5
II. Нийгмийн даатгал	6
III. Эрүүл мэнд.....	6
IV БОЛОВСРОЛ	7
v. Гэмт хэргийн нөхцөл байдал.....	9
БҮЛЭГ II ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ.....	10
VI. Орон нутгийн төсвийн орлого, зарлага.....	10
VII. Мөнгө, зээл, хадгаламж	10
VIII Дотоодын нийт бүтээгдэхүүн.....	11
IX. Хэрэглээний үнэ	12
X. Хөдөө аж ахуй.....	13
XI. Аж үйлдвэр.....	14

НЭГ. АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Нийгмийн халамж:** Монгол Улсын хуулиар олгож буй тэтгэвэр тэтгэмжид хамрагдаж байгаа хүний тоо болон мөнгөн дүнгээр оруулсан./ХХҮГ/
- **Нийгмийн даатгал:** Монгол Улсын хуулиар олгож буй тэтгэвэр тэтгэмжид хамрагдаж байгаа хүний тоо болон мөнгөн дүнгээр оруулсан./НДХ/
- **Эрүүл мэнд:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Гэмт хэрэг:** Аймгийн цагдаагийн газраас захиргааны статистик мэдээгээр нэгтгэн гаргадаг.
- **Эрүүгийн хуульд** эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл өөрчлөгдсөн.

 - Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.
 - Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
 - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдыг эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
 - Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.
 - Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
 - 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.
- **Мөнгө, банк:** Монгол банк арилжааны банкнуудаас мэдээг авч нэгтгэн, банкнуудын үндсэн материалын хамт ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.

- **Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.
- Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар өрхөөс цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

БҮЛЭГ I НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ

I Нийгмийн халамж



Нийгмийн халамжийн сангаас 2024 оны 2 сард нийт 62123 хүнд 11.263.5 сая төгрөгийн олголт хийж, үүнээс халамжийн тэтгэвэр 1811 хүнд 1.221.6 сая төгрөг, халамжийн тэтгэмж 1845 хүнд 1.019.3 сая төгрөг, амьжиргаа дэмжих мөнгөн тусламж 544 хүнд 211.7 сая төгрөг, жирэмсэн эхийн тэтгэмжид 677 эхчүүдэд 46.9 сая төгрөг, Алдарт эхийн одонгийн тусламж 8131 эхэд 1.026.5 сая төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж 2 хүнд 0.5 сая төгрөг, насны хишиг 4157 хүнд 343.5 сая төгрөг, цалинтай ээж хөтөлбөрийн хүрээнд 3790 ээжид 367.4 сая төгрөг, өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөрийн хүрээнд 13 хүнд 3.7 сая төгрөг, ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж 1 хүнд 2.0 сая төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжид 33823 хүүхдэд 6.836.1 сая төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх үйлчилгээ 5174 хүнд 129.6 сая төгрөг, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт, тусламж 2102 хүнд 38.8 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа тусламж, хөнгөлөлт 49 хүнд 11.1 сая төгрөг, амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум хорооны нийгмийн ажилтанд олгох урамшуулал 0 хүнд 0 төгрөг, орон нутгийн төсвөөс амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 4 хүнд 4.8 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Ажилгүйдэл, Ажлын байр, Ажиллагсад

2024 оны 02 сарын байдлаар аймгийн бүртгэлтэй ажилгүй иргэд 493 байгаагаас, нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 247 буюу 50.1 хувь нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-44 насныхан 84.9 хувь буюу 419 иргэн, 45 дээш насныхан 74 иргэн 15.01 хувийг эзэлж байна. Харин боловсролын түвшинээр нь харвал боловсролгүй 2 иргэн үүнээс эмэгтэй 2, бага боловсролтой 15 иргэн үүнээс 6 эмэгтэй, суурь боловсролтой 28 иргэн үүнээс 15 эмэгтэй, бүрэн дунд хүртэл боловсролтой 303 иргэн үүнээс 147 эмэгтэй, техникийн болон мэргэжлийн боловсролтой 101 иргэн үүнээс 51 эмэгтэй, тусгай мэргэжлийн боловсролтой 14 иргэн үүнээс 6 эмэгтэй, дипломын дээд боловсролтой 22 иргэн үүнээс 13 эмэгтэй, бакалаврын боловсролтой 18 иргэн үүнээс 10 эмэгтэй, магистр, докторын боловсролтой 2 иргэн үүнээс 1 эмэгтэй байна, хувиар харвал боловсролгүй иргэн 0.4 хувь, бага боловсролтой 3.0 хувь, суурь боловсролтой 5.6 хувь, бүрэн дунд хүртэл боловсролтой 61.4 хувь, техникийн болон мэргэжлийн боловсролтой 20.5 хувь, тусгай мэргэжлийн боловсролтой 2.8 хувь, дипломын дээд боловсролтой 4.5 хувь, бакалаврын боловсролтой 3.7 хувь, магистр, доктор боловсролтой иргэд 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Улирлын шинэ ажлын байранд нийт 1 иргэн ажилд орсон бөгөөд 35-44 насны эрэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Улирлын шинэ ажлын байранд ажиллаж байгаа иргэдийг эдийн засгийн салбараар харвал Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажлын салбарт 1 хүнд улирлын шинэ ажлын байр гаргаж ажиллаж байна.

2024 оны 02 сарын байдлаар 19 ажлын байрны захиалга ирсэн байна. Ажлын байрны захиалгыг ажил мэргэжлийн ангиллаар харвал Менежер 1, Мэргэжилтэн 7, Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн 0, Контор, үйлчилгээний ажилтан 2, Худалдаа, үйлчилгээний ажилтан 3, Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан 0, Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил 1, үйлчилгээний ажил 0, Суурин

төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч 0, Зэвсэгт хүчний ажил, мэргэжил 0, Энгийн ажил, мэргэжил салбарт 5 ажлын байрны захиалга тус тус иржээ.

Эхний 2 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдээс 96 хүн ажилд зуучлагдан орсон ба 53 иргэн буюу 55.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажилд орсон иргэдийн 62.5 хувь нь 15-44 насныхан байжээ. Ажилд зуучлагдан орсон иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар харвал Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур 19, Уул уурхай олборлолт 5, Боловсруулах үйлдвэр 19, Цахилгаан, хий, уур агааржуулалт 0, Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт 28, барилга 2, Бөөний болон жижиглэн худалдаа машин мотоциклийн засвар үйлчилгээ 6, Тээвэр ба агуулахын үйлчилгээ 0, Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ 3, мэдээлэл холбоо, Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 0, Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа 0, Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа 0, Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 0, Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал 4, боловсрол 4, Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа 1, Урлаг, үзвэр, тоглоом наадам 0, Үйлчилгээний бусад үйл ажиллагаа 5, Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллангаа 0, Олон улсын байгууллага суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт 0 тус тус зуучлагдан ажилд оржээ.

Эх үүсвэр: аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар

II. Нийгмийн даатгал



2024 оны эхний 2 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэрт 13.818.8 сая төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 1.476.1 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 461.9 сая төгрөг, цэргийн тэтгэвэрт 144.3 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 214.5 сая төгрөг, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжид 367.2 сая төгрөг, оршуулгын тэтгэмжид 124.0 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэрт 7.6 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 16.7 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 87.0 сая төгрөг тус тус олгожээ.

Эх үүсвэр: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс

III. Эрүүл мэнд



Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 2 сард 216 эх төрж, өнгөрсөн оны мөн үеэс 48 төрөлтөөр буурсан байна. Нийт төрсөн эхийн 96.3 хувь нь аймгийн Нэгдсэн эмнэлэгт, 3.7 хувь нь сумын эмнэлэгт төрсөн.

Эхний 2 сард аймгийн хэмжээнд нийт 127 халдварт өвчин бүртгэгдэж 10.000 хүн амд 14.3 байгааг 2023 оны мөн үетэй (12.0) харьцуулахад өссөн байна. БЗДХ-ын тохиолдлын тоо урьд оны мөн үеэс буурч 75 байгаа нь нийт халдварт өвчний 59.1 хувийг эзэлж байна. Бүртгэгдсэн БЗДХ-ын 75 тохиолдлын 29.3 хувийг заг хүйтэн, 42.6 хувийг трихомоназ, 28.1 хувийг тэмбүүгийн өвчлөл тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд нийт нас баралтын 66 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 11 тохиолдлоор буурч, нийт нас баралтын 18.2 хувь нь эмнэлэгт нас барснаас 33.0 хувь нь хоног болоогүй нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс (2023 онд 23.7 хувь эмнэлэгт нас барсан) нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд хорт хавдрын 14, осол

гэмтлийн 6 нас баралт бүртгэгдсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад осол гэмтлийн шалтгаант нас баралт буурч, хорт хавдрын шалтгаант нас баралт нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Эхний 2 сард нийт 2580 түргэн тусламжийн дуудлага бүртгэгдсэний 22.6 хувийг алсын, 6.8 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад түргэн тусламжийн нийт дуудлагын тоо, нийт дуудлагад эзлэх алсын болон осол гэмтлийн дуудлагын тоо тус тус буурсан байна.

Эх үүсвэр: аймгийн Эрүүл мэндийн газар

IV БОЛОВСРОЛ



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

Ерөнхий боловсролын сургуульд 2023-2024 оны хичээлийн жилд 19162 суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс суралцагчдын тоо 444 (2.3%) хүүхдээр өсжээ.


Нийт суралцагчдын 9563 (48.9%) нь 1-5-р ангид, 6936 (35.4%) нь 6-9-р ангид, 2083 (15.7%) нь 10-12-р ангид суралцаж байна.

Энэ хичээлийн жилд 1-р ангид 1901 суралцагчид элсэн орсны 967 (50.9%) эмэгтэй суралцагчид байна. Мөн 12-р ангид 856 суралцагчид байгаагийн 452 (52.8%) нь эмэгтэй суралцагчид байна.


Энэ хичээлийн жилд 691 бүлэг хичээллэж байгаа бөгөөд нэг ангид 27 суралцагч ногдож байна. Нэг багшид ногдох суралцагчийн тоо 20 байна.

Нийт ажиллагсдын 1016 (55%) үндсэн багш байна. Үндсэн багшийн 820 (80.7%) нь эмэгтэй багш нар байна. Дотуур байранд 1859 сурагч амьдарч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 50 (2.6%) сурагчаар өсжээ.

ЗУРАГ 1. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД ӨДРӨӨР СУРАЛЦАГЧИД, жил бүрийн хичээлийн жилд



ЗУРАГ.2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШ жил бүрийн хичээлийн жилд




СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ


2023-2024 оны хичээлийн жилд 216 бүлэгт 7513 хүүхэд хүмүүжиж байна. Өмнөх оны мөн үеэс 1568 (27.1%) мянган хүүхдээр өсжээ.

42 сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 7513 хүүхдэд 259 багш, нийт 914 ажилчин боловсролын үйлчилгээ үзүүлж байна.

ЗУРАГ 3. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГАД ХАМРАГДСАН ХҮҮХДИЙН ТОО, жил бүрийн хичээлийн жилд



ЗУРАГ 4. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН БАГШ, жил бүрийн хичээлийн жилд



Эх үүсвэр: аймгийн Боловсрол Шинжлэх Ухааны газар

v. Гэмт хэргийн нөхцөл байдал



Тус цагдаагийн газар нь 2024 оны 2 сард иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 694 дуудлага, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үеийнхээс 38 нэгжээр буюу 11.1 хувиар өссөн. Үүнээс 250 буюу 36.0 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 444 буюу 64.0 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 22 буюу 8.8 хувийг 5 хоногт, 147 буюу 58.8 хувийг 6-19 хоногт, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 410 буюу 92.3 хувийг 5 хоногт тус тус шалгаж шийдвэрлэжээ.

Хүлээн авч шалгасан гомдол, мэдээллээс гэмт хэргийн шинжтэй 80 буюу 32 хувийг, зөрчлийн шинжтэй 25 буюу 5.6 хувийг тус тус шийдвэрлээгүй, хуулийн хугацаанд шалгагдаж байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг

Аймгийн хэмжээнд энэ хугацаанд 123 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 41 нэгжээр буюу 50.0 хувиар өссөн.


Энэ хугацаанд хэрэг бүртгэлтийн 101 хэрэг бүртгэгдсэнээс 13 хэргийн холбогдогчийг яллагдагчаар татаж ял сонгосон. Нийт гэмт хэргийн илрүүлэлт 12.9 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 14.8 пунктээр буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 86 буюу 69.9 хувь нь Баянхонгор суманд, 37 буюу 30.1 хувь нь бусад сумдад үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал:

Бүртгэгдсэн гэмт хэргийн 102 буюу 82.9 хувь нь хөнгөн ангиллын, 21 буюу 17.1 хувь нь хүнд ангиллын гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

ЗУРАГ.5.Үйлдэгдсэн гараг:




Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, байгууллага:

Гэмт хэргийн улмаас 114 иргэн хохирч, үүнээс 39 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 9 нэгжээр буюу 30 хувиар, 5 хүн нас барсан нь 5 нэгжээр буюу 100 хувиар тус тус өссөн.

Гэмт хэргийн улмаас 944.2 сая төгрөгийн хохирол учирснаас 58.4 сая төгрөгийг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 6.2 хувьтай байна.

ЗУРАГ.6.Үйлдэгдсэн цаг:



ХҮСНЭГТ-1 ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ БАРАГДУУЛАЛТ

Он сар	Хохирол	Нөхөн төлүүлэлт	Битүүмжилсэн хөрөнгө
2023.02	472.7	17.7	0.5
2024.02	944.2	58.4	14.2

Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Энэ хугацаанд нийт 44 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 нэгжээр буюу 18.9 хувиар өссөн бөгөөд 8 эмэгтэй хүн холбогдон шалгагдсан нь ижил түвшинд байна.

Зөрчлийн мэдээ

Аймгийн хэмжээнд 2024 оны 2 сард нийт 5636 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 596 буюу 11.8 хувиар, 5560 зөрчил шийдвэрлэсэн нь 580 буюу 11.6 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 4548 буюу 80.7 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 277 буюу 4.9 хувийг Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 52 буюу 0.9 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 434 буюу 7.7 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан 5453 иргэнд 163174.5 сая төгрөгөөр торгох, 69 хүнийг баривчлах, 30 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 8 хүнийг баривчлуулж, эрх хасах шийтгэл тус тус ногдуулсан нь өмнөх оноос торгох шийтгэл 596 буюу 12.3 хувиар өсч, баривчлах шийтгэл 32 буюу 86.5 хувиар тус тус өсч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 56 буюу 65.1 хувиар тус тус буурсан байна.

Эх үүсвэр: аймгийн Цагдаагийн газар

БҮЛЭГ II ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

VI. Орон нутгийн төсвийн орлого, зарлага



2024 оны 2 сарын байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 5.225.0 сая төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 2656.3 сая төгрөгөөр өссөн байна. 2024 оны 2 сарын нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг Галуут, Эрдэнэцогт, Гурванбулаг, Жаргалант, Өлзийт, Бөмбөгөр, Хүрээмарал, Баянбулаг, Заг, Жинст, Богд, Баянлиг, Баянговь, Баян-Өндөр, Баянцагаан, Шинэжинст, Баацагаан, Бууцагаан сумууд давуулан биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: НӨАТ 158.7 сая төгрөг, агаарын бохирдол /авто/ 10.7 сая төгрөг, ус бохирдуулсны төлбөр 6.1 сая төгрөг, ЦХХТА орлого /суутган-1/ 638.4 сая төгрөг, газрын төлбөр 29.2 сая төгрөг, агнуурын нөөц ашигласны төлбөр 60.2 сая төгрөг, хог хаягдлын хураамж 77.9 сая төгрөг, Улсын тэмдэгтийн хураамж 18.2 сая төгрөг, хүү торгуулийн орлого 33.6 сая төгрөг, ҮХЭХ борлуулсны орлого 26.9 сая төгрөгөөр тус тус тасарч, орон нутгийн автозам ашигласны хураамж 19.0 сая төгрөг, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн татвар 33.6 сая төгрөг, ус рашаан ашигласны төлбөр 2.0 сая төгрөг, ҮХЭХ-ийн татвар 1.1 сая төгрөг, малын тоо толгойн татвар 78.2 сая төгрөгөөр тус тус давуулан биелжээ.

Нийт орлогод нэмэгдсэн өртгийн албан татвар 9.5 хувь, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн татвар 1.4 хувь, хүү торгууль 5.3 хувь. ЦХХТА орлого (суутган) 36.3 хувь, ААНОАТ (60%) 10.5 хувь, бусад төлбөр хураамж 37.0 хувийг тус тус эзэлж байна.

Эх үүсвэр: аймгийн Татварын хэлтэс

VII. Мөнгө, зээл, хадгаламж



Монгол Банкны аймаг дахь салбараас ирүүлсэн мэдээгээр 2024 оны 2 дугаар сарын 29-ны байдлаар арилжааны банкнуудын нийт зээлийн

үлдэгдэл 350.736.6 сая төгрөг байгаагийн 5.347.2 сая төгрөг нь анхаарал хандуулах зээл /хугацаа хэтэрсэн/, 5.878.9 сая төгрөг нь чанаргүй зээл байна.

2024 оны 2 сард нийт хадгаламжийн үлдэгдэл 156.683.6 сая төгрөг байна. Үүний 26.569.9 сая төгрөг нь хугацаагүй хадгаламж, 130.160.9 сая төгрөг нь хугацаатай хадгаламж байна.

ХҮСНЭГТ-2

		Мян.төг
		Үлдэгдэл
		Үзүүлэлт
Зээл	Нийт зээлийн үлдэгдэл	350,736,620.3
	Үүнээс: Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл	5,347,223.9
	Чанаргүй зээлийн үлдэгдэл	5,878,948.5
Татан төвлөрүүлсэн хөрөнгө	Нийт харилцахын үлдэгдэл	49,336,714.3
	Үүнээс: Иргэдийн харилцахын үлдэгдэл	32,068,117.5
	Нийт хадгаламжийн үлдэгдэл	156,730,861.8
	Үүнээс: Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл	156,683,593.1
	Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	26,569,912.0
	Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	130,160,949.8
Тоон мэдээлэл	Нийт банкны салбар, нэгжийн тоо	54
	Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо	227
	Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор)	62763
	Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	151411
	Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	66824
	Нийт АТМ-ны тоо	46
	Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо	68882

Эх үүсвэр: Баянхонгор аймаг дахь Монгол банкны салбар

VIII Дотоодын нийт бүтээгдэхүүн



Аймгийн ДНБ (оны үнээр) 2022 онд 537.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 53.6 хувиар өслөө. Аймгийн ДНБ улсын дүнд 1.0 хувийг эзэлж байна.

Аймгийн ДНБ-ийг томсгосон 3 салбар буюу хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний салбараар харьцуулан авч үзвэл, 2022 онд ДНБ-ий 263.6 (49.1%) тэрбум төгрөгийг хөдөө аж ахуйн салбар, 74.6 (13.9%) тэрбум төгрөгийг үйлдвэрлэлийн салбар, 199.2 (37.1%) тэрбум төгрөгийг үйлчилгээний салбар бүрдүүлжээ.


Хөдөө аж ахуйн үйл ажиллагаа сэргэсэнтэй холбоотой өмнөх оноос хөдөө аж ахуйн салбар 2.0 дахин, үйлдвэрлэлийн салбар 61.3 хувиар нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ-3. ДНБ, салбараар

	ДНБ	НӨ-ийн жилийн цэвэр өөрчлөлт						
		Хөдөө аж ахуй	Үйлдвэрлэл	Үйлчилгээ	ДНБ	Хөдөө аж ахуй	Үйлдвэрлэл	Үйлчилгээ
2019	454.0	232.3	74.2	147.4	22.2	20.9	40.3	16.7
2020	572.6	301.9	115.4	155.3	26.1	29.9	55.5	5.3
2021	350.0	131.0	46.2	172.8	-38.9	-56.6	-59.9	11.3
2022	537.4	263.6	74.6	199.2	53.6	2.0*	61.3	15.3

*- дахин их


ЗУРАГ 7. АЙМГИЙН ДНБ-ИЙ БҮТЭЦ, салбараар, дүнд эзлэх хувь



ДНБ-ий 2022 оны салбарын бүтцийг өмнөх оныхтой харьцуулбал, 2021 онд хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа буурсантай холбоотой хөдөө аж ахуйн салбарын оролцоо 11.7 нэгж хувиар нэмэгдэж,

үйлчилгээний салбарын оролцоо 12.3 нэгж хувиар буурсан байна.

ЗУРАГ 8. НЭГ ХҮНД НОГДОХ ДНБ, сая төгрөг



Нэг хүнд ногдох ДНБ аймгийн дүнгээр 2020 онд 6.5 сая төгрөг байсан бол хөдөө аж ахуйн салбарын бууралттай холбоотой 2021 онд 3.9 сая төгрөг хүртэл буурч, харин 2022 онд 6.0 сая төгрөгт хүрсэн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ): Тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд тайлант хугацаанд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн шинээр бүтээсэн нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм.

Эх үүсвэр: ҮСХ, Бүс нутгийн ДНБ-ий гүйцэтгэл

IX. Хэрэглээний үнэ



Аймгийн өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн ерөнхий индекс 2024 оны 2 сарын байдлаар өмнөх сартай харьцуулснаар 1.2 хувиар өсчээ, ийнхүү өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн барааны үнэ, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад, зочид буудал нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн бүтээгдэхүүний үнэ тус тус өссөн нь нөлөөлжээ.

Харин өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн ерөнхий индекс 2 дугаар сарын байдлаар өмнөх оны жилийн эцэстэй харьцуулснаар 2.6 хувиар өсчээ, ийнхүү өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн барааны үнэ, зочид буудал нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн бүтээгдэхүүний үнэ, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад бараа үйлчилгээ бүлгийн бүтээгдэхүүний үнэ тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.7 хувиар өссөн нь хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн барааны үнэ, зочид буудал нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн бүтээгдэхүүний үнэ, боловсролын үйлчилгээ бүлгийн бараа бүтээгдэхүүний үнэ, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ бүлгийн барааны үнэ, гэр ахуйн бараа бүлгийн бараа бүтээгдэхүүний үнэ өссөнтэй холбоотойгоор өссөн нь харагдаж байна.

ХҮСНЭГТ-4 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс

№	Барааны бүлгээр	2024.02/	2024.02/	2024.02/
		2023.02	2023.12.	2024.01
	Ерөнхий индекс	107.7	102.6	101.2
1	Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	113.2	110.2	104.0
2	Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	102.5	98.5	98.1
3	Хувцас, бөс бараа, гутал	103.8	99.1	98.7
4	Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад	105.3	103.4	101.6
5	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	106.3	99.7	99.3
6	Эм тариа эмнэлгийн үйлчилгээ	106.8	99.7	98.8
7	Тээвэр	101.4	99.9	99.9
8	Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	101.1	100.0	100.0
9	Амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	104.4	97.4	97.1
10	Боловсролын үйлчилгээ	110.6	100.0	100.0
11	Зочид буудал нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	112.3	110.3	108.6
12	Бусад бараа үйлчилгээ	109.7	103.1	101.7

Эх үүсвэр: ҮСХ, Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээ

Х. Хөдөө аж ахуй



Мал тооллогын дүнгээр 2023 оны жилийн эцэст манай аймгийн мал сүргийн нийт дүн 4072.2 мянга болж, 2022 оны нийт дүнгээс 9.5 хувь буюу 352.6 мянган толгойгоор өсчээ. Урьдчилсан дүнгээр адуун сүргийн тоо 177.3 мянга, үхэр 238.2 мянга, тэмээ 48.9 мянга, хонь 1218.4 мянга, ямаа 2389.3 мянган толгой болж өмнөх оныхоос адуу 16.9 мянга (10.6%), үхэр 15.2 мянга (6.8%), тэмээ 3.4 мянга (7.5%), хонь 110.4 мянга (10.0%), ямаа 206.6 мянган (9.5%) толгойгоор буюу таван төрөл дээр өссөн байна.

Нийт мал сүргийн дотор адуу 4.4 хувь, үхэр 5.8 хувь, тэмээ 1.2 хувь, хонь 29.9 хувь, ямаа 58.7 хувийг тус тус эзэлж, өмнөх оныхоос үхрийн эзлэх хувь 0.2 пунктээр буурч, адуу, хонины эзлэх хувь 0.1 пунктээр тус тус өсч, тэмээ, ямааны сүрэгт эзлэх хувьд өөрчлөлт ороогүй байна.

ХҮСНЭГТ-5

Малын төрөл	Малын тоо 2023 онд				мян.тол	
	Малын тоо		2023/2022		Нийт дүнд эзлэх хувь	
	2022	2023	Зөрүү	Хувь	2022	2023
Бүгд	3719.6	4072.2	352.6	109.5	100.0	100.0
Адуу	160.4	177.3	16.9	110.6	4.3	4.4
Үхэр	222.9	238.2	15.2	106.8	6.0	5.8
Тэмээ	45.5	48.9	3.4	107.5	1.2	1.2
Хонь	1108.1	1218.4	110.4	110.0	29.8	29.9
Ямаа	2182.7	2389.3	206.6	109.5	58.7	58.7

2024 оны 2 дугаар сарын том малын зүй бус хорогдлын мэдээгээр нийт 97373 толгой мал хорогдсон нь оны эхний малын 2.4 хувийг эзэлж байна. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл тэмээ, адуу 3350, үхэр 16545, хонь 25360, ямаа 52032 толгой тус тус хорогджээ.

Эх үүсвэр: ҮСХ, Хөдөө аж ахуйн мэдээ

XI. Аж үйлдвэр



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт 2024 оны 2 дугаар сард өссөн дүнгээр 4,155.9 сая төгрөгт хүрчээ. Өмнөх оны мөн үеэс 1,863,4 сая төгрөг буюу 31.0 хувиар буурсан байна.

Нийт үйлдвэрлэлтийг салбараар авч үзвэл: Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар 2,377.3 сая төгрөг буюу 57.2 хувь, боловсруулах аж үйлдвэр 122.1 сая төгрөг буюу 2.9 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалт үйлдвэрлэл 1,300.1 сая төгрөг буюу 31.3 хувь, ус хуримтлуулах, ариутгах, түгээх, үйл ажиллагаа 275.1 сая төгрөг буюу 6.6 хувь, хог хаягдлыг цуглуулах, зайлуулах үйлчилгээ 81.3 сая төгрөг буюу 2.0 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ-6 Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн борлуулалт

Үзүүлэлт	2023 II	2024 I	2024 II	мян.төг
				2024 I 2024 II
Нийт дүн	6,019,295.1	8,694,536.7	4,155,900.4	47.8
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	4,230,736.9	6,653,671.5	2,377,272.0	35.7
Чулуун нүүрс олборлолт	206,572.0	265,900.0	220,000.0	82.7
Өнгөт төмөрлөгийн хүдэр олборлолт	4,024,164.9	6,387,771.5	2,157,272.0	33.7
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ	205,138.6	220,717.0	122,134.1	55.3
Мах боловсруулах, консервлох	18,070.0	22,570.0	28,000.0	123.9
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	9,000.0	9,600.0	9,815.0	102.0
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	171,868.6	155,087.0	69,283.1	44.7
Бусад даавуун эдлэл үйлдвэрлэл	1,200.0	1,620.0	5,700.0	351.9
Үслэг арьсан хувцаснаас бусад хувцас үйлдвэрлэл	0.0	30,400	6,636.0	21.8
Арьс шир идээлэх, элдэх, боловсруулах	5000.0	1,440.0	2,700.0	187.5
ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ	1,354,006.6	1,368,301.3	1,300,101.2	95.1
Ус хуримтлуулах, ариутгах, түгээх үйл ажиллагаа	198,761.9	281,080.2	275,139.7	97.9
Хог хаягдлыг цуглуулах	30,651.1	170,766.7	81,253.4	48.0

Эх үүсвэр Аж үйлдвэрийн мэдээ

Мэдээлэл авах холбоосууд: <http://www.bayankhongor.nso.mn/>
<http://www.1212.mn/> Утас: 70442081: 70442403

ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭСЭН. МЭРГЭЖИЛТЭН Д.АРИУНБУЯН

ХЯНАСАН: ХЭЛТСИЙН ДАРГА Г.ГАНЧИМЭГ

